Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын судалгааны үр дүн

Л.Хишигдэлгэр, Г.Ганхуяг, Ц.Басбиш, Б.Оюунгоо
Сувилахуйн сургууль, АШУҮИС,
E-mail: khishigdelger@mnums.edu.mn, Утас: +976-99073269

Түлхүүр үг:

Хөтөлбөр,
үр дүн,
үнэлгээ,
алсын хараа

Товч утга: Их дээд сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хөтөлбөрийн эрхэм зорилго, нэгжийн эрхэм зорилго нь суралцахуйн үр дүнд шууд нөлөөлдөг. Тухайлбал их сургуулийн урт хугацааны төлөвлөлт, алсын хараа, эрхэм зорилгыг хангахад тухайн хөтөлбөр өөрийн үүргээ хэрхэн гүйцэтгэж ямар чадамжтай төгсөгч бэлтгэх ёстойг тодорхойлдог байна[1]. ДЭМБ-ын 2021-2025 онд хэрэгжүүлэх Сувилахуй, эх барихуйн стратегийн тэргүүлэх чиглэлд боловсролын чанарын асуудлыг нэн тэргүүнд тавьсан билээ. МУ-ын хувьд Сувилахуйн боловсролын хэтийн төлөв, баримтлах зарчим, стратегийг тодорхойлох, чанар сайжруулах-төгсөгчөө сургууль хариуцдаг тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажлуудыг эхлэхээр төлөвлөж байна.[2] Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр шинээр боловсруулах ажлын хүрээнд хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтуудыг шинэчлэн тодорхойлох эсвэл өөрчлөлт хийж буй тохиолдолд (РЕО)-г сургуулийн алсын хараа эрхэм зорилго, зорилттой уялдуулах ёстой. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу сувилахуйн оюутны сэтгэл ханамж болон нэгж хичээлийн үр дүн (CEQ)-ийн түвшин дунд байна. ҮДСБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын оролцоог тодорхойлоход маш өндөр (r=0.87), багш нарын оролцоонд удирдлагын дэмжлэг өндөр (r=0.81), сургалтын хөтөлбөрт эрхэм зорилго зорилт дунд (r=0.69) хамааралтай байгаа нь РЕО тодорхойлоход эрхэм зорилго, зорилтын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Үндэслэл: Дэлхийн улс орнуудад дээд боловсролын багш төвтэй сургалтаас суралцагч төвтэй сургалтанд шилжих, суралцахуйн үр дүнг суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар үнэлэх, асуудалд суурилсан сургалтаар дамжуулан суралцагчдад багаар ажиллах болон бусад чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулахад багш нарын чадвар, чадамж, оролцоо шууд хамааралтай байдаг байна[1,5]. Олон улсын түвшинд “Тухайн дээд боловсролын байгууллага сургалт явуулж байгаа хөтөлбөрийнхөө суралцахуйн үр дүн (PLO) буюу оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг урьдчилан тодорхойлж, хүрэх үр дүнгээ төсөөлсөн байх ба сургалт явагдсаны дараа төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхээр үнэлэгдэх сургалтыг үр дүнд суурилсан боловсрол” гэж тодорхойлдог. Үр дүнд суурилсан сургалтыг төлөвлөхдөө багш нар эдгээр үр дүнг харуулахын тулд оюутнуудад юу сурах ёстойг заадаг. Бүх оюутнууд ижил аргаар, ижил хугацаанд ижил түвшинд суралцах боломжгүй гэж үздэгээрээ уламжлалт боловсролоос ялгаатайгаар арга барилын цогц шинж чанар нь үнэлгээнд мөн тусгагдсан байдаг. Үнэн хэрэгтээ үнэлгээний хамгийн жижиг нэгж ч гэсэн эрүүл мэндийн практикт хэрэглэж болохуйц мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг цогц байдлаар хамрах ёстой[13]. Их дээд сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хөтөлбөрийн эрхэм зорилго, нэгжийн эрхэм зорилго нь суралцахуйн үр дүнд шууд нөлөөлдөг. Тухайлбал их сургуулийн урт хугацааны төлөвлөлт, алсын хараа, эрхэм зорилгыг хангахад тухайн хөтөлбөр өөрийн үүргээ хэрхэн гүйцэтгэж ямар чадамжтай төгсөгч бэлтгэх ёстойг тодорхойлдог байна[1]. ДЭМБ-ын 2021-2025 онд хэрэгжүүлэх Сувилахуй, эх барихуйн стратегийн тэргүүлэх чиглэлд боловсролын чанарын асуудлыг нэн тэргүүнд тавьсан байна. МУ-ын хувьд Сувилахуйн боловсролын хэтийн төлөв, баримтлах зарчим, стратегийг тодорхойлох, чанар сайжруулах-төгсөгчөө сургууль хариуцдаг тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажлуудыг эхлэхээр төлөвлөж байна[2]. Сувилахуйн сургууль нь ҮДСБ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLO)-г тодорхойлохдоо сургалтын үйл ажиллагаа, агуулга,

үнэлгээтэй уялдуулах тал дээр илүү анхааран ажиллаж байна. Суралцахуйн үр дүнгийн хэсэгт сургууль, хөтөлбөр, хичээлийн түвшинд тус тус сургалтын төсөөлсөн үр дүнг урьдчилан тодорхойлох бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудаас сургалтын төсөөлсөн үр дүн буюу оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагуудыг тэдний хэрэгцээ шаардлагатай уялдуулдаг учраас энэхүү судалгааг хийсэн болно.[3,6]

Зорилго, зорилт: Сургууль хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг тодорхойлох зорилгоор дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1. Сургууль хөтөлбөр хэрэгжүүлэгч хамтын ажиллагааны оролцоог үнэлэх
2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн буюу (PLO)-г үнэлж, хөтөлбөрийн хүрэх үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох

Материал арга зүй: Судалгааг нэг агшингийн (cross-sectional) судалгааны аргаар Context-Input-Process-Product буюу CIPP загварт суурилсан үнэлгээний аргачлалаар хөтөлбөрөөр тодорхойлсон үнэт зүйлийн гол үзэл санааг философийн орчин үеийн хандлагын үүднээс үнэлэх, үнэт зүйл, үзэл баримтлалтай хөтөлбөрийн зорилго, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн зохицол нийцэл, зорилго, агуулга, төлөвлөлт орц, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн бүтээгдэхүүний тохирлыг үнэлэх хөтөлбөрийн үнэлгээний арга зүйг боловсруулж, “5=маш сайн”-аас “1=муу” хүртэлх үнэлгээгээр үнэлүүлэн дундаж үзүүлэлт, ач холбогдлын түвшинг сургуулийн удирдлага, багшлах бүрэлдэхүүн, ҮДСБ-ыг олгох сургууль, салбар тэнхимийн алсын хараа, эрхэм зорилго, дотоод гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагын шалгуур үзүүлэлттэй уялдуулах судалгаа хийх замаар тодорхойллоо.Судалгааны өөрийн үнэлгээний асуумжинд АНУ-ын North Carolina Анагаахын сургуулиас 2011 онд боловсруулан 2016 онд дахин сайжруулалт хийсэн стандарт 4 бүлэг бүхий стандарт асуумж, Hsiu-Chin, Huan-Sheng Lo (Utah Valley University, Utah, 2 Department of Behavior Science, Utah Valley University, Utah) нарын боловсруулсан Nursing Student Satisfaction Scale буюу (PLO)- хөтөлбөрийн үр дүнг үнэлэх стандарт асуумжийг тус тус ашиглан судалгааны мэдээллийг цуглуулав. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 3-аас дээш жил ажилласан туршлага бүхий 53 багш, 134 төгсөх дамжааны оюутнуудыг хамруулж, судалгааны мэдээллийг дескриптив болон пирсоны корреляцийн аргаар хамаарлыг үзэж, боловсруулалтыг SPSS 25 программаар гүйцэтгэсэн. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг Ёс зүйн хяналтын хорооны 2022.01.21-ний өдрийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл авч гүйцэтгэсэн.

Үр дүн: Сувилахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 73 чиглэлийн хичээл, сургалтын үйл ажиллагаагаар нийт 5760 сургалтын цагийг биелүүлэх 75 багшийн бүрэлдэхүүнээс бакалаврын сургалтыг удирдан явуулдаг 53 багшийг хамруулж, тэнхим, албан тушаал, боловсролын зэрэг, албан тушаал, насны үзүүлэлт, ажилласан жилээр ерөнхий мэдээллийг цуглуулсан болно (хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогсдын хүн ам зүйн мэдээлэл (хувь, давтамж, n=86)

Хувьсагч	Давтамж N=53	Хувь 100%
Нас (жилээр)		
25-30	4	7.7
31-35	18	34.6
36-40	6	11.5
41-45	7	13.5
46-50	10	18.8
51-ээс дээш	8	15.4
Хүйс		
Эрэгтэй	14	26.4
Эмэгтэй	39	73.6

Албан тушаал		
Дэд профессор	2	3.8
Ахлах багш	12	23.1
Багш	32	61.5
Дадлагажигч багш	6	11.5
Боловсролын зэрэг		
Доктор	9	16.9
Магистр	44	83.1
Сургуульд ажилласан жил		
1-5 жил	10	18.8
6-10 жил	15	28.3
11-15 жил	16	30.1
16-20 жил	6	11.3
21-25 жил	4	7.5
26-аас дээш жил	2	3.7
Сургалтаар биелүүлж буй хувь		
11-20 хувь	1	1.8
21-30 хувь	5	9.4
31-40 хувь	5	9.4
41-50 хувь	14	26.4
51-ээс дээш хувь	28	52.8
Эрдэм шинжилгээгээр биелүүлж буй хувь		
0-10 хувь	22	41.5
11-20 хувь	14	26.4
21-30 хувь	9	16.9
31-40 хувь	5	9.4
41-50 хувь	2	3.7
51-ээс дээш хувь	1	1.8
Мэргэжлийн үйл ажиллагаагаар биелүүлж буй хувь		
0-10 хувь		
11-20 хувь	25	47.1
21-30 хувь	19	35.8
31-40 хувь	7	13.2
Бусад үйл ажиллагаагаар биелүүлж буй хувь	2	3.7
0-10 хувь		
11-20 хувь	45	84.9
21-30 хувь	7	13.2
	1	1.8

Судалгаанд хамрагдсан багш нарын 61,5% нь багшийн статус дээр ажиллаж буй багш нар байсан бөгөөд ажлын туршлагын хувьд авч үзэхэд 6-10 жил ажилласан (30.8), боловсролын зэргээр 80,8% нь магистрын зэрэгтэй багш нар байв. Сургалтын ачаалалыг 7 хоногт гүйцэтгэдэг тогтмол цагийн ачаалалаар тооцоход (59.6) нь 31-40 цаг биелүүлдэг байна.

Сургуулийн эрхэм зорилго, удирдлагын дэмжлэг, багшийн оролцоо, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн бага, их утга, дундаж, стандарт хазайлтыг тодорхойлсон. (хүснэгт 2).

Хүснэгт 2. Сургууль хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын хамтын ажиллагааны оролцооны зарим үзүүлэлт

	Үзүүлэлт	N=53	Бага утга	Их утга	Дундаж	(±) Стандарт хазайлт
1	**Эрхэм зорилго**	53	12.00	20.00	17.19	±2.02
2	**Удирдлагын дэмжлэг**	53	24.00	73.00	36.78	±6.87
3	**Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр**	53	47.00	85.00	64.35	±8.21
4	**Багшийн оролцоо**	53	84.00	157.00	117.95	±14.34

Сургуулийн эрхэм зорилго, удирдлагын дэмжлэг, багшийн оролцоо, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр, сургуульд ажилласан жил, сургалтын 7 хоногийн цагийн ачаалал зэрэгт хамаарлын шинжилгээ хийсэн (хүснэгт 3). Суралцахуйн үр дүн болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үнэлэх судалгаанд Сувилахуйн сургуулийн бакалаврын хөтөлбөрийн 125 оюутан оролцсоноос 91.9% нь 20-24 насныхан, ихэнх хувь нь эмэгтэй (97.7), талаас дээш хувь 2018 онд элссэн байв. Nursing Student Satisfaction Scale буюу (NSSS/ үнэлгээгээр хөтөлбөрийн үр дүнг үнэлэх (PLO) стандарт асуумжийн дотоод найдвартай байдлын кронбах альфа нь 0.96 байв. Дэд бүлэг болох сургалтын хөтөлбөр ба заах арга зүйн дундаж 42.95± 8.39, орчин дэд бүлгийн дундаж 13.98±3.29, мэргэжлийн харилцаа дэд бүлгийн дундаж 30.44±6.33, нийт сувилахуйн оюутны сэтгэл ханамжийн дундаж нь 87.28±16.72 байв.

Хүснэгт 3. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн

Оюутны сэтгэл ханамж (IY дамжаа)	**Pearson Correlation**	**Сургалтын хөтөлбөр ба заах арга зүй**	**Сургалтын хэрэглэгдэхүүн**	**Мэргэжлийн багш нарын харилцаа**
		0.673**	0.663**	0.879**

Оюутны сэтгэл ханамж нь (PLO) хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэйгээ хамааралтай байна. Ялангуяа сургалтын хөтөлбөр ба заах арга зүйн хамаарал нь 0.06, мэргэжлийн багш нарын харилцаа нь 0.87 байна.

Хүснэгт 4. Сургуулийн эрхэм зорилго, зорилт, сургалтын хөтөлбөр болон сургалтын хөтөлбөр удирдлагын дэмжлэг багш нарын оролцооны хамаарал

Pearson correlation			Сургуулийн эрхэм зорилго	Удирдлагын дэмжлэг	Багшийн оролцоо	ҮДСБ-ын хөтөлбөр
Эрхэм зорилго, зорилт	Pearson correlation		1			
	Sig.(2-tailed)	000				
	N.	50				
Удирдлагын дэмжлэг	Pearson correlation	.503**		1		
	Sig.(2-tailed)	000				
	N.	45				

Багшийн оролцоо	Pearson correlation	695**	1	
	Sig.(2-tailed)	000		
	N.	45		
ҮДСБ-ын хөтөлбөр	Pearson correlation	557**		1
	Sig.(2-tailed)	000		
	N.	45		

Хүснэгтээс харахад сургуулийн эрхэм зорилго, зорилт нь сургалтын хөтөлбөртэй, сургалтын хөтөлбөр удирдлагын дэмжлэгтэй багш нарын оролцоо сургуульд ажилласан жилтэй шууд (хүчтэй/ ($p<0.05$) хамааралтай байгаа нь хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд тавигдах шаардлагын дагуу боловсруулагдсан бөгөөд удирдлагын дэмжлэг багш нарын ажилласан жилтэй хамааралгүй байна.

Хэлцэмж:

Дээд боловсролын сургалтын системд заах болон суралцах чанарт дэлхий нийтээр ихээхэн анхаарал хандуулж байна. Бидний судалгааны үр дүнд байгууллагын эрхэм зорилго, зорилт, удирдлагын дэмжлэг, хамт олны харилцаа нь багшийн оролцоо сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй хамааралтай байна. Өмнөх судлаачдын үр дүнгээс харахад анагаахын их дээд сургуулийн багш нарын ажлын сэтгэл ханамж, оролцоо дунд түвшинд байсан ба үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамт олны харилцаа, удирдлагын дэмжлэг шууд хамааралтай байсан. (Schubert-Irastorza & Fabry, 2014). Англи улсын Dundee Анагаахын Их сургууль нь үр дүнд суурилсан сургалтыг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн агуулгын давхардал арилсан, багшийн хамтын ажиллагаа, оролцоо нэмэгдсэнийг тодотгожээ. (Davis, 2003).

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу сувилахуйн оюутны сэтгэл ханамж болон нэгж хичээлийн үр дүн (CEQ)-ийн түвшин дунд байна.
- ҮДСБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын оролцоог тодорхойлоход маш өндөр ($r=0.87$), багш нарын оролцоонд удирдлагын дэмжлэг өндөр ($r=0.81$), сургалтын хөтөлбөрт эрхэм зорилго зорилт дунд ($r=0.69$) хамааралтай байгаа нь РЕО тодорхойлоход эрхэм зорилго, зорилтын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Номзүй:

1. Эрдэнэхүү Н, Нямсүрэн П, Уганбаяр П, Мөнхбаяр А. Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж, УБ 2017: 9-27.
2. ЭМЯ, Сувилахуйн тусламж үйлчилгээний гарын авлага. 2016.
3. Амартүвшин Т. Сувилахуйн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн судалгаа АУ-ны магистрын зэрэг горилсон судалгааны ажлын бүтээл УБ 2021
4. Wald HS, Borkan JM, Taylor JS, Anthony D, Reis SP. Fostering and evaluating reflective capacity in medical education: developing the REFLECT rubric for assessing reflective writing. Acad Med. 2012;87(1):41-50.
5. Newman MJ. Problem Based Learning: an introduction and overview of the key features of the approach. J Vet Med Educ. 2005;32(1):12-20.
6. Mennenga HA, Smyer T. A model for easily incorporating team-based learning into nursing education. Int J Nurs Educ Scholarsh. 2010;7:Article4.
7. Wilford A, Doyle TJ. Integrating simulation training into the nursing curriculum. Br J Nurs. 2006;15(17):926-930.
8. Hakan K, Seval F. CIPP evaluation model scale: development, reliability and validity. Procedia-Social and Behavioral Sciences. 2011;15:592-599.
9. Brama CJ. Flipping the classroom. Retrieved,. 2013 August 29.
10. Одонжил П. Үр дүнд суурилсан сувилахуйн хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар боловсруулан, туршсан үр дүн. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. 2019;
11. Megan Lippe, Patricia Carter. Using the CIPP model to Assess Nursing Education Program Quality and Merit, 2017
12. Caratas Khakan, Fer Seval. CIPP evaluation model scale: development, reliability and validity, Procedia Social and Behavioral Sciences 15(2011); 592-599
13. Khanna, R., & Mehrotra, D. (2019). The roadmap for quality improvement from traditional through competency based (CBE) towards outcome based education (OBE) in dentistry. Journal of oral biology and craniofacial research, 9(2), 139.

Abstract

Research results of Stakeholders in implementation of Nursing Curriculum

Khishigdelger.L, Gankhuyag.G, Basbish.Ts, Ouyngoo.B
Nursing School, MNUMS,
E-mail: Khishigdelger@mnums.edu.mn, Tel: 976-99073269

Keywords:

Program,
results,
evaluation,
vision

Summary: University vision, mission, program mission, and unit mission directly affect learning outcomes. For example, the university's long-term planning, vision, and mission determine how the program should play its role and prepare competent graduates1. The quality of education is a priority of the WHO's Nursing and Obstetrics Strategy for 2021-2025. Mongolia plans to begin work on defining the perspectives, principles and strategies of nursing education, and introducing a quality improvement-graduate school-based system. Revise curriculum education goals and objectives as part of developing a new curriculum based on results-based education methodologies or in the event of a change (PEO), the school's vision should be aligned with its mission and objectives.

As part of the development of a new curriculum in accordance with a results-based education methodology, the educational goals and objectives of the curriculum (PEO) should be aligned with the school's vision and objectives. Curriculum learning outcomes, such as nursing student satisfaction and unit learning outcomes (CEQ), are in the middle. Very high (r = 0.87) in determining the participation of teachers in the implementation of the HSE program, high management support for teacher participation (r = 0.81), and correlation between the mission in the curriculum (r = 0.69) coordination needs to be improved.